

2026 оны 01 сарын 29 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

**“Худалдаа, хөгжлийн банк” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн
хараат бус гишүүнийг түр томилох тухай**

Компанийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.5 дахь хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, “Худалдаа, хөгжлийн банк” ХК-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.6 дахь хэсэг, Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Цалин, урамшууллын болон нэр дэвшүүлэх хорооны 2025 оны 12 дугаар сарын 24-ны өдрийн хурлын тэмдэглэл болон Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн Худалдаа, хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

1. Компанийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1 дэх хэсэг, Банкны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.3 дахь хэсэгт заасан шаардлагыг бүрэн хангаж буй Лувсангийн Нямсүрэнг 2026 оны 1 дүгээр сарын 30-ны өдрөөс эхлэн нөхөн сонгууль хүртэл “Худалдаа, хөгжлийн банк” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр түр томилсугай.
2. “Худалдаа, хөгжлийн банк” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр түр томилогдсон Л.Нямсүрэнд Компанийн тухай хууль, Банкны тухай хууль болон “Худалдаа, хөгжлийн банк” ХК-ийн дүрэмд заасан Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүний бүрэн эрхийг хэрэгжүүлж ажиллахыг үүрэг болгосугай.
3. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж, шаардлагатай арга хэмжээг авч ажиллах, холбогдох мэдээллийг хууль тогтоомжид заасны дагуу эрх бүхий байгууллагад хүргүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Ажлын алба (Н.Нямсүрэн)-нд үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ**ЗӨВЛӨЛИЙН ДАРГА****РАНДОЛФ КОПИА**